ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/26 Хажуу шинэ-Ус

Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, Бог малын мялзан,
шүлхий өвчнийг эрт илрүүлэх үзлэгийг хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 05 сарын 01-ны хооронд төл мал (ишиг)-д заавар зөвлөмжийн дагуу чанартай хийж гүйцэтгэхийг Угтаал чандмань хоршооны малын их эмч (Д. Амгалан)-д даалгасугай.

2.Бог малын мялзан, шүлхий өвчний эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж сумын хэмжээний бог мал, үхрийг хамруулж ажиллахыг Угтаал чандмань хоршооны малын их эмч (Д. Амгалан)-д даалгасугай.

3.Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт Бог малын мялзан, шүлхий өвчний эрт илрүүлэх үзлэгт хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (А. Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.АРИУНАА